

2023



ЖИЛИЙН
ТАЙЛАН

АГУУЛГА

01	ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ	4
02	КОМПАНИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ	5
03	КОМПАНИЙН ТУХАЙ	6
	3.1. Алсын хараа	6
	3.2. Эрхэм зорилго	6
	3.3. Үнэт зүйлс	6
	3.4. Зарчим	6
	3.5. Биржийн үйл ажиллагааны тойм	7
04	КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ	8
	4.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал	8
	4.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа	9
	4.3. ТУЗ-ийн хороодын чиг үүрэг, танилцуулга	10
05	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН	11
	5.1. Журам, зохицуулалт	11
	5.1.1. Шинэчлэгдсэн болон шинээр баталсан журмууд	11
	5.2. Үндсэн үйл ажиллагаа	12
	5.2.1. Арилжаа	12
	5.2.2. Тооцооны үйл ажиллагаа	13
	5.2.3. Бүртгэл	14
	5.2.4. Гишүүнчлэл	15
	5.2.5. Эрсдэлийн удирдлага	15
	5.3. Системийн хөгжүүлэлт	16
	5.4. Бизнесийн үйл ажиллагаа	16
	5.4.1. Шинэ бүтээгдэхүүн судалгаа, хөгжүүлэлт	16
	5.4.2. Хамтын ажиллагаа	17
	5.4.3. Сургалт	18
	5.5. Бүтэц, удирдлага	18
06	САНХҮҮГИЙН ТАЙЛАН	19

ТОВЧИЛСОН ҮГС

Бирж-“Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК
СЗХ-Санхүүгийн зохицуулах хороо
ҮЦТХТ-Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
ХЭХ-Хувьцаа эзэмшигчдийн хурал
ТУЗ-Төлөөлөн удирдах зөвлөл
API-Application Programming Interface

01

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

М.ДАВААЖАРГАЛ

Гүйцэтгэх захирал
“Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК

“Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК (Бирж)-ийн Хувьцаа эзэмшигчид, нийт гишүүд, зах зээлийн мэргэжлийн оролцогчид та бүхний амар мэндийг эрэн мэндчилье.

2021 онд үйл ажиллагаандаа шинэчлэл, ре-брендинг хийснээр 2022 оноос олон улсын биржүүдийн жишгийн дагуу хотынхоо нэрээр нэрлэгдэх болж, Улаанбаатар Үнэт Цаасны Бирж нэрийн дор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг хурдасгах, түргэн шуурхай, найдвартай үйлчилгээг үзүүлэх бодлогын хүрээнд шинийг санаачлан ажиллахаар зорьсон жил боллоо.

2023 онд Биржийн гишүүдийн тоо 26, тооцооны гишүүдийн нийт тоо 16 болж нэмэгдсэн бөгөөд гишүүддээ үзүүлэх хөнгөлөлт урамшууллын бодлогыг баталсан. Хөрөнгийн зах зээлд цоо шинэ бүтээгдэхүүн болох Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сан буюу ETF санг бүртгэлээ. Түүнчлэн, ууган финтек компани болох МОСТ Финтек ХК-ийн анх удаа нийтэд санал болгохоор гаргасан энгийн хувьцааг бүртгэсэн ба сангийн нэгж эрх, хувьцааны арилжааг амжилтай зохион байгуулж, биржийн үйл ажиллагаа идэвхэжсэн жил өнгөрлөө.



Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд олон сорилтууд тулгарч байгаа ч бид зах зээлийн дэд бүтцийн байгууллагын хувьд тэдгээрт тохирсон уян хатан зохицуулалт, систем, үйл ажиллагааны болон стратеги бодлогын шинэчлэлүүдийг цаг тухай бүрд нь хийж, зах зээлийн оролцогчид болон бизнес эрхлэгчдэд таатай боломжуудыг бий болгох ажлуудыг тасралтгүй хийсээр байна.

Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг шинэ түвшинд хүргэх их үйлсэд бидэнтэй хамтран, үргэлж дэмжин ажилладаг эрхэм хувьцаа эзэмшигчид, зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагууд та бүхэнд талархал илэрхийлье!

02

КОМПАНИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ

2008
ОН

Мосдак Дат
Судалгаа төслийн
үндэс тавигдав.

2009
ОН

Насдак
Хамтын ажиллагааны
төслийн зөвлөгөө.

2015
ОН

МҮЦБ
Үнэт цаасны
арилжаа, тооцооны
тусгай зөвшөөрөл.

2016
ОН

MSX Платформ
Өөрсдийн арилжаа,
тооцооны системийг
нэвтрүүлэв.

2022
ОН

УБҮЦБ
Менежментийн болон
дүрэм журмын
шинэчлэлийг зохион
байгуулав.

2021
ОН

Rebranding
Шинэ стратегийн
хөрөнгө оруулагчтай
болж, системийн
шинэчлэлийг
амжилттай дуусган,
UBX платформ
нэвтрүүлэв.

2018
ОН

ОТС/FX
Судалгаа төсөл
эхлүүлэв.
Анхны бонд Минж
пропертис ХК-г
бүртгэв.

2017
ОН

IPO
Анд Энерги ХК
Анхны хувьцаат
компанийг бүртгэв.

2023
ОН

АНХНЫ ETF, IPO
Монголын анхны хамтын биржээр
арилжаалагддаг “Инвекстор Глобал
Кью” ETF хөрөнгө оруулалтын сангийн
нэгж эрх болон МОСТ Финтек ХК-ийн
энгийн хувьцааг бүртгэв.

03

КОМПАНИЙН ТУХАЙ



АЛСЫН ХАРАА

Бүс нутгийнхаа хөрөнгийн зах зээлийн төв болох



ЭРХЭМ ЗОРИЛГО

Хөрөнгийн зах зээлийн тэргүүлэгч цахим бирж байх



ҮНЭТ ЗҮЙЛС

- Хурд
- Үр ашиг
- Засаглал
- Уян хатан бодлого
- Харилцагчийн нууцлал
- Мэргэжлийн ёс зүй

ЗАРЧИМ

- Хүний эрх, эрхэм чанарыг дээдэлж ажиллана;
- Сайн засаглал, ил тод байдлыг байгууллагын бүх төвшинд нэвтрүүлэн ажиллана;
- Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдэлж ажиллана;
- Нээлттэй уян хатан бодлого баримталж, зах зээлийн мэдрэмжтэй, хурдан шуурхай ажиллахыг эрмэлзэнэ;
- Хөрөнгийн зах зээлд шинэ, олон улсын жишигт нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж, манлайлах бодлогыг мөрдөж ажиллана;
- Хууль эрх зүйн болон бизнесийн орчиндоо шаардагдаж буй өөрчлөлтүүдийг бий болгохын төлөө санаачилга гаргаж ажиллана;
- Харилцагчийн хэрэгцээ шаардлагад нийцэх, найдвартай, аюулгүй, цахим систем, дэд бүтцийг нэвтрүүлэн ажиллана;
- Харилцагчийн үйлчилгээг дээд зэрэгт барих бодлогыг чандлан мөрдөнө;
- Хамгийн авьяаслаг, хүчирхэг, мэргэжлийн, үйл хэрэгтээ үнэнч хамт олныг бүрдүүлж, ёс зүйн хэм хэмжээг ямагт өндөрт тогтоон дагаж, хууль тогтоомжийг чандлан мөрдөж ажиллана;
- Нийгмийн хариуцлага өндөртэй, нийгэмд эерэг өөрчлөлтийг түүчээлэх, байгаль орчин, эх дэлхийгээ хайрлан хамгаалах чиг хандлагыг үйл ажиллагаандаа шингээж ажиллахыг эрхэмлэнэ.

3.5 БИРЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ



26

АРИЛЖААНЫ ГИШҮҮН



16

ТООЦООНЫ ГИШҮҮН



4

ЗАХ ЗЭЭЛ ҮҮСГЭГЧ



АРИЛЖАА, ТООЦОО:

2023 онд Биржийн зах зээлд нийт 248 удаагийн 6,419,773,746.45 төгрөгийн арилжаа явагдаж, хоёрдогч зах зээлийн арилжааны 1,292,907,333 төгрөгийн төлбөр тооцоог хийж гүйцэтгэсэн.

ГИШҮҮНЧЛЭЛ:

2023 онд шинээр 3 арилжааны гишүүн, 9 тооцооны гишүүн элсэж Биржийн нийт арилжааны гишүүдийн тоо 26, тооцооны гишүүдийн тоо 16 болов.

БҮРТГЭЛ:

Бирж нь Бүртгэлийн хорооны 4 удаагийн хараат бус хурлыг зохион байгуулж “Инвестор Глобал Кью” хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сан болон “Мост Финтек” ХХК-ийн энгийн хувьцааг бүртгэж анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаатай холбоотой баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллав.

СИСТЕМ:

ГрэйпСити Монгол ХХК-аас хөгжүүлсэн клирингийн цогц системийг нэвтрүүлэх төслийн хүрээнд хамтарсан туршилтыг амжилттай хийж гүйцэтгэсэн.

МАРКЕТИНГ, ХАМТЫН АЖИЛЛАГАА:

Хөрөнгийн зах зээлийн тал бүрийн оролцогчдод зориулсан хамтын ажиллагааг өргөжүүлсэн бөгөөд үнэт цаас гаргахаар зэхэж буй байгууллагуудад аудит, санхүүгийн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх, хөрөнгийн зах зээл, санхүү, бизнесийн мэдээллийг баталгаат эх сурвалжтай хүргэх хүрээнд аудит болон медиа компаниудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, сургалт орсон.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ:

Менежментийн баг шинэчлэгдсэн, засаглалын кодекст заасан журмуудыг батлуулахын сацуу Дотоод үйл ажиллагаатай холбогдуулан Дотоод журмын нэмэлт өөрчлөлтийг болон, архив албан бичгийн журмыг шинээр батлуулсан.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 оны 3 сарын 23-ны 145 тоот тогтоолоор “Компанийн засаглалын кодекс”-ийг шинэчлэн баталсан. Үүний хүрээнд кодексийг хэрэгжүүлэхээр Компанийн засаглалын үнэлгээг хийж түүний дагуу төлөвлөгөө гарган шаардлагатай компанийн засаглалын журмуудыг баталж эхэлсэн бөгөөд компанийн засаглалыг зөв, үр нөлөөтэй зохион байгуулах тал дээр бэлтгэл ажлуудаа ханган ажиллалаа.




График 1. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

4.1. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Бирж нь нийт 32 хувьцаа эзэмшигчтэй бөгөөд Биржийн толгой компани болох “Даац инвестмент” ХХК 63.4 хувийг эзэмшдэг бол үлдсэн 36.6 хувийг 31 жижиг хувьцаа эзэмшигчид хуваан эзэмшиж байна.

2023 онд Биржийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүчин төгөлдөр хуралдаж нийт 2 тогтоол гаргасан байна.

№	Огноо	Ирц	Батлагдсан тогтоолын тоо
1	2023.04.24	82.92%	2

Хүснэгт 1. Хувьцаа эзэмшигчдийн хурал

4.2. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГА

Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн стратеги төлөвлөгөө боловсруулах, төсөв батлах, хувьцаа эзэмшигчдийг хуралдуулах, үнэт цаас, ногдол ашигтай холбоотой шийдвэрүүд гаргах, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавин чиглүүлэх, санхүүгийн тайлан болон ил тод байдлыг хянах, охин болон хараат компанийн удирдлагыг хэрэгжүүлэх зэргээр ажиллана. ТУЗ нь хороодын байнгын үйл ажиллагааг нь ханган ажилладаг.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН



Ч.ГАНЗОРИГ
АЙДАКС ХХК
Гүйцэтгэх Захирал




Ч.НЯМДОРЖ
ТЭРГЭЛ МЕНЕЖМЕНТ ХХК
Захирал



Ө.АШХҮҮ
АРД МЕНЕЖМЕНТ ҮЦК
Хуульч



Ж.ЗОЛЗАЯА
АРД СЕКЮРИТИЗ ҮЦК
Төлөөлөн удирдах
зөвлөлийн гишүүн



Б.ЗОЛБОО
АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК
Гүйцэтгэх захирлын үүрэг
гүйцэтгэгч



С.ЦЭРЭН
МОН ЧИН ХХК
Захирал


ХАРААТ БУС ГИШҮҮД:



Б.АНХБОЛД
БУЛИГААР ХК
Захирал



Ц.БАТСҮХ
Санхүү эдийн засгийн
их сургуулийн
профессор



О.ОДСАЙХАН
HUAWEI TECHNOLOGIES
компанийн Хэрэглэгчтэй
харилцах албаны дарга

Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн холбогдох заалтад нийцүүлэн ТУЗ-ийн дэргэд дараах 3 байнгын хороод байгуулагдан ажиллаж байна. Үүнд, Аудитын хороо, Хөрөнгө оруулалт, санхүү, эрсдэлийн хороо, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо багтана.

4.3. ТУЗ-ИЙН ХОРООДЫН ЧИГ ҮҮРЭГ, ТАНИЛЦУУЛГА

АУДИТЫН ХОРОО

- Аудитын хорооны дарга: Б.АНХБОЛД
- Аудитын хорооны гишүүд: Ц.БАТСҮХ, Ч.НЯМДОРЖ

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь дотоод хяналтын тогтолцоог хянах, сайжруулах, аливаа эрсдэлийг тодорхойлон засах, санхүүгийн тайлангийн үнэн зөв, ил тод байдлыг хянан сайжруулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хянаж зөвлөмж гарган хөндлөнгийн аудиторуудтай хамтран ажиллах, дотоод хяналтын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх компанийн үйл ажиллагаа холбогдох хууль журмуудын дагуу явагдаж байгаа эсэхийг шалгаж үнэлэлт дүгнэлт өгөх ба ТУЗ-ийг чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлэх зорилготой.

ЗАСАГЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРОО

- Засаглал нэр дэвшүүлэх цалин урамшууллын хорооны дарга: О.ОДСАЙХАН
- Засаглал нэр дэвшүүлэх цалин урамшууллын хорооны гишүүд: Ө.АШХҮҮ, Б.АНХБОЛД

ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн бусад гишүүд болон албадын захирал зэрэг эрх бүхий албан тушаалд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулахад оролцох, эрх бүхий албан тушаалтнуудын ажлын гүйцэтгэлийг хянах, тэдгээрийн цалин урамшууллыг нэмэгдүүлэхэд санал өгөх, компанийн засаглалын ил тод байдлыг сайжруулах талаар санал гарган ТУЗ-д танилцуулах, ТУЗ-с үүрэг болгосон бусад ажлуудыг гүйцэтгэх, засаглалын зарчмыг хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавих зорилготой.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ САНХҮҮ ЭРСДЭЛИЙН ХОРОО

- Хөрөнгө оруулалт санхүү эрсдэлийн хорооны дарга: Ж.ЗОЛЗАЯА
- Хөрөнгө оруулалт санхүү эрсдэлийн хорооны гишүүд: Б.ЗОЛБОО, О.ОДСАЙХАН

ТУЗ-ийн дэргэдэх Хөрөнгө оруулалт санхүү эрсдэлийн хороо нь хөрөнгө оруулалтын чиглэлээр компанийн стратегийн төлөвлөгөө боловсруулахад оролцох ба гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавин төсөл, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд эрсдэлийн урьдчилсан дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд удирдамж чиглэл өгөх үйл ажиллагаа эрхлэн явуулдаг.

Тайлант хугацаанд Биржийн ТУЗ 11 удаа хуралдсан бөгөөд дундаж ирц 84.7% байна. 2023 онд ТУЗ-өөс Биржийн үйл ажиллагаатай холбоотой нийт 39 тогтоолыг батлан гаргасан байна.

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо 4 удаа, Хөрөнгө оруулалт, санхүү эрсдэлийн хороо 4 удаа, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо 3 удаа тус тус хуралдаж хариуцсан чиг үүргийнхээ хүрээнд зөвлөмж, дүгнэлтүүд гарган ажиллалаа.

№	Огноо	Ирц	Батлагдсан тогтоолын тоо	№	Огноо	Ирц	Батлагдсан тогтоолын тоо
1	2023.01.11	77.7%	7	7	2023.09.18	88.8%	2
2	2023.02.09	77.7%	3	8	2023.10.05	100%	3
3	2023.03.10	88.8%	5	9	2023.11.27	100%	3
4	2023.05.24	77.7%	6	10	2023.12.01	77.7%	2
5	2023.06.16	66.6%	1	11	2023.12.26	88.8%	6
6	2023.07.27	88.8%	2				

Хүснэгт 2. ТУЗ-ийн хурлын ирц, тогтоол

05 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАИЛАН

5.1. ЖУРАМ ЗОХИЦУУЛАЛТ

Биржийн хувьд 2023 онд дараах журам зохицуулалтуудыг баталж ажилласан. Үүнд:



Шимтгэл хураамжийн журмын нэмэлт өөрчлөлт



Дотоод журмын нэмэлт өөрчлөлт



Албан хэрэг хөтлөлтийн журам



Мэдээллийн ил тод байдал, тайлагналын



Цалин урамшууллын бодлого



Оролцогч талуудтай харилцах, хамтран

5.1.1. ШИНЭЧЛЭГДСЭН БОЛОН ШИНЭЭР БАТАЛСАН ЖУРМУУД

Компанийн засаглалын кодексийн шинэчлэлтэй уялдуулан байгууллагын удирдлага болон ажиллагсдын дотооддоо баримтлах, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах Дотоод журам, Албан хэрэг хөтлөлтийн журмыг тус тус шинэчлэн баталлаа. Мөн компанийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам, Цалин урамшууллын бодлого болон Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогыг тус тус Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлууллаа.

Шимтгэл хураамжийн журмын нэмэлт өөрчлөлтийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 20/23 болон 24/23 тоот тогтоолоор тус тус баталсан. Журамд гишүүнчлэл, бүртгэлийн хураамж болон бусад үйлчилгээний хураамжтай холбоотой заалтуудыг нэмж шимтгэл хураамжийн хувь, хэмжээнд өөрчлөлт оруулсан

5.2. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Арилжаа



Тооцооны үйл
ажиллагаа



Бүртгэл




Гишүүнчлэл



Эрсдэлийн
удирдлага

5.2.1. АРИЛЖАА



Тайлант хугацаанд “Инвекор Глобал Кью” (INQ) хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сан болон “Мост Финтек ХК” (MOST)-ийн энгийн хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулсан. 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 248 өдрийн арилжаа явагдаж, 6,419,773,746.45 төгрөгийн үнийн дүн бүхий, 145,216,398 ширхэг хувьцаа болон хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх арилжигдсан байна.

Нэр	Тикер	Дээд ханш	Доод ханш	Дундаж ханш	Хаалтын ханш
Анд Энерги ХК	AND	31 ₮	22 ₮	25.8 ₮	31 ₮
Инвекор Глобал Кью	INQ	540 ₮	515 ₮	528.3 ₮	540 ₮
Мост Финтек ХК	MOST	55.7 ₮	48 ₮	44.8 ₮	55.7 ₮

Хүснэгт 3. Биржид бүртгэлтэй үнэт цааснуудын 2023 оны ханшийн мэдээлэл

2023 оны хамгийн өндөр дүнтэй арилжаа явагдсан сар нь 12 дугаар сар бөгөөд нийт 6,412,432,297.45 төгрөгийн үнийн дүнтэй арилжаа явагдсан байна. Жилийн эцсийн байдлаар хамгийн өндөр дүн бүхий арилжааг “Ард Секюритиз ҮЦК” ХХК хийжээ.

Арилжааны бодит цагийн болон арилжааны дараах өдөр тутмын мэдээллийг бид www.ubx.mn цахим хаягаар дамжуулан олон нийтэд тогтмол хүргэж байна. Мөн дотоод мэдээлэл эзэмшигчид болон арилжаанд оролцогч бусад этгээдүүд зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх үүднээс үнэт цаасны компаниуд болон үнэт цаас гаргагчтай хамтран арилжааны хяналтыг гүйцэтгэж байна.

№	Үнэт цаасны компани	Арилжааны дүн /төгрөг/
1	“Алтан хоромсог ҮЦК” ХХК	6,000.00
2	“Аргай Бэст ҮЦК” ХХК	1,050.00
3	“Ард Секюритиз ҮЦК” ХХК	782,188,522.90
4	“Инвекор Капитал ҮЦК” ХХК	11,561,612.00
5	“Новел Инвестмент ҮЦК” ХХК	8,531.00
6	“Таван Богд Капитал ҮЦК” ХХК	1,091,955.00
7	“Ти Ди Би Секьюритис ҮЦК” ХХК	488,748,629.60

Хүснэгт 4. Хувьцааны хоёрдогч зах зээлд оролцсон үнэт цаасны компаниудын идэвх

5.2.2. ТООЦООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улаанбаатар Үнэт Цаасны Бирж ХК нь 2023 онд Биржийн зах зээлд нийт 1120 хэлцэл хийгдэж, эмхэтгэсэн дүнгээр 1,292,907,333.00 төгрөгийн үнийн дүн бүхий тооцоог хийж гүйцэтгэв.

Биржээр арилжаалсан үнэт цаасны тооцооны үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэд дэлгэрэнгүй харууллаа.

№	Тооцооны гишүүн	Тооцооны гишүүний төрөл	Үнэт цаасны тикер	Тооцооны дүн, ₮
1	Ард Секюритиз ҮЦК	ШУУД	AND	13,464,818
2	Ард Секюритиз ҮЦК	ШУУД	INQ	1,328,500
3	Ард Секюритиз ҮЦК	ШУУД	MOST	795,616,972.91
4	Инвекор капитал ҮЦК	ШУУД	AND	69,400
5	Инвекор капитал ҮЦК	ШУУД	INQ	11,492,212
6	Новел Инвестмент ҮЦК	ШУУД	INQ	8,531
7	Новел Инвестмент ҮЦК	ШУУД	MOST	90,000
8	Таван Богд Капитал ҮЦК	ШУУД	AND	2,800
9	Таван Богд Капитал ҮЦК	ШУУД	INQ	1,089,155
10	Ти Ди Би Секьюритис ҮЦК	ШУУД	AND	3,000
11	Ти Ди Би Секьюритис ҮЦК	ШУУД	INQ	3,920,936
12	Ти Ди Би Секьюритис ҮЦК	ШУУД	MOST	484,824,693.57

Хүснэгт 5. Биржийн хэлцэл /эмхэтгэсэн дүнгээр/

2023 оны жилийн эцсийн байдлаар Улаанбаатар Үнэт Цаасны Бирж нь 3 тооцооны ерөнхий гишүүн, 13 тооцооны шууд гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

5.2.3. БҮРТГЭЛ

Бирж нь 2023 оны БХ-01/23 тоот тогтоолоор Инвекор Ассет Менежмент ҮЦК-ийн үүсгэн байгуулсан “Инвекор Глобал Кью хамтын биржээр арилжаалагддаг ХОС” ХХК-ийн нэгж эрхийг үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн. Тус сангийн нэгж эрхийн танилцуулгыг Санхүүгийн Зохицуулах Хороо 2023 оны 401 тоот тогтоолоор бүртгэснээр анхдагч зах зээлд үнэт цаасаа солилцож, хоёрдогч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулсан.



Мөн Биржийн 2022 оны БХ-02/22 тоот, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2023 оны 508 тоот тогтоолоор МОСТ Финтек ХК-ийн энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг зөвшөөрч анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэхэд шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэн, арилжааг амжилттай зохион байгуулсан.



Бирж нь бүртгэлийн үйл ажиллагааны хүрээнд үнэт цаас гаргах боломжит компаниудтай уулзалт зохион байгуулж мэдээллээр хангаж ажиллаж байна. Мөн бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, материал, ТУЗ-ийн хурлын зар, материалыг хүлээн авч, үнэт цаас гаргагчдаас шаардлагатай мэдээ, мэдээллийг ирүүлэхийг шаардаж ажилласан. Биржийн систем, журмуудын шинэчлэлтэй холбоотойгоор хэрэгцээт мэдээллийг бүртгэлтэй үнэт цаас гаргагчдад тухай бүр хүргэж ажиллаж байна. Бирж бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх үүднээс Бүртгэлийн хороо болон Биржид бүртгэлтэй Нийцүүлэгчийг бүртгэлийн үйл ажиллагаанд оролцуулдаг. 2023 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар Бүртгэлийн хороо нийт 12 гишүүнтэй бөгөөд нийт 29 нийцүүлэгч Биржид бүртгэлтэй байна. Эдгээр гишүүд нь ажиллаж буй салбартаа 5-аас доошгүй жил ажилласан, мэргэжлийн болон ёс зүйн хариуцлагатай, хараат бус гишүүд байна.

Бирж үнэт цаас гаргагчид зөвлөгөө өгөх үүргийнхээ хүрээнд шинээр үнэт цаас гаргах зорилготой 10 гаруй компанитай уулзалт зохион байгуулсан. Мөн Биржид үнэт цаас бүртгүүлэх сонирхолтой компаниудад бүртгэлийн шалгуур, үе шат, баримт бичгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл бүхий танилцуулга илгээж ажиллалаа.


5.2.4. ГИШҮҮНЧЛЭЛ

Бирж нь 2023 оны жилийн эцсийн байдлаар 26 арилжааны гишүүн, 13 тооцооны шууд гишүүн, 3 тооцооны ерөнхий гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант хугацаанд 7 үнэт цаасны компани Арилжаа болон Тооцооны гишүүнээр элсэж, 2 үнэт цаасны компани арилжааны гишүүн болж, 3 арилжааны гишүүн Тооцооны шууд гишүүний гэрээ байгууллаа.

2023 онд Биржийн гишүүдэд шинэчлэгдсэн болон шинээр батлагдсан журмын танилцуулгыг цахим уулзалтаар дамжуулан хүргэж, журмын нэмэлт, өөрчлөлтүүдэд гишүүдийн саналыг авч тусгасан.

5.2.5. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Бирж нь эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг 3 түвшинд хэрэгжүүлдэг бөгөөд Биржийн мэргэжилтэн бүр хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх үүрэгтэй ажиллана. Биржийн эрсдэлийн удирдлага дараах бүтцийн дагуу хэрэгжиж байна.



Арилжааны эрсдэлийн удирдлага

Дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох, зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэхийн тулд биржийн арилжааны систем нь дотоод мэдээлэл эзэмшигчдийг бүртгэж, дотоод мэдээлэл эзэмшигчийн дансаар хийгдсэн захиалга болон хэлцлийн жагсаалтыг биржийн арилжааны дансаар салгаж харуулдаг. Ингэснээр хяналт, шалгалтыг бодит цагийн горимоор болон арилжааны дараа хийх боломжтой болсон.

Тооцооны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Бирж нь 2023 онд тооцооны үйл ажиллагааны эрсдэлээс сэргийлэх үүднээс тооцооны гишүүдээс барьцаа, дэнчингийн доод үлдэгдлийг журамд заасны дагуу тогтмол хангуулж ажиллалаа. Арилжаанд оролцож буй оролцогчдын байршуулах дэнчингийн хувь хэмжээг 20 хувиас доошгүй байхаар, барьцаа хөрөнгийн доод үлдэгдлийг тогтмол дүнгээр Тооцооны ерөнхий гишүүд 10,000,000 төгрөг, Тооцооны шууд гишүүд 2,000,000 төгрөг байхаар тогтоосон. 2023 оны байдлаар тооцооны гишүүд төлбөрийн чадварын эрсдэлд орсон тохиолдол гараагүй байна.

5.3. СИСТЕМИЙН ХӨГЖҮҮЛЭЛТ

UBX платформын захиалга хүлээн авах хүчин чадал, тулгалт хийх хурд болон мэдээллийн аюулгүй байдал, тогтвортой, найдвартай үйл ажиллагааг хэвийн явуулахаар системийн хөгжүүлэлт, сайжруулалтуудыг өдөр тутамдаа хийж ажилласан.

Арилжааны системд мэргэжлийн оролцогчид холбогдож захиалгын менежмент хийх FIX гарцын хөгжүүлэлт шинээр хийж туршилтын ажлыг эхлүүлсэн, Зах зээлийн мэдээлэл түгээх FAST гарцын хөгжүүлэлтийг хийж байна. FIX/FAST гарцууд нь ҮЦК-иудын ашиглаж буй системүүдийг UBX платформтой холбох ажлыг хөнгөвчлөх зорилготой юм.

5.4. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.4.1. ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН СУДАЛГАА, ХӨГЖҮҮЛЭЛТ

ETF олон улсын судалгаа хийж, Монгол улсад бүтээгдэхүүн гаргахаар оролцогч талууд болон кастодиан, хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд, үнэт цаасны компаниудтай уулзалт хийж, бэлтгэл ажлыг хангаснаар Монголын анхны хамтын биржээр арилжаалагддаг “Инвескор Глобал Кью” ETF хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулагдаж, тус сангийн нэгж эрхийн арилжааг хөрөнгийн зах зээлд амжилттай нэвтрүүллээ. Байгууллагын WEB хуудсыг шинэчлэх ажлыг эхлүүлсэн.

“IPO 45”

Аж ахуй нэгжүүдэд IPO хийх процессыг илүү хялбар ойлгомжтой болгох зорилгоор “IPO 45” хөтөлбөрийг батлан уулзалт, сургалтуудыг тогтмол зохион байгуулж байна.



5.4.2. ХАМТЫН АЖИЛЛАГАА

Улаанбаатар Үнэт Цаасны Бирж нь Нексия Глобал Монголиа Аудит ХХК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Үүний хүрээнд биржид бүртгүүлэхээр зэхэж буй компаниудад санхүүгийн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх, бүртгүүлсэн компаниудад санхүүгийн тайлагналын олон улсын стандарттай холбоотой зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах зорилгоор “Нексия Глобал Монголиа Аудит”-тай хамтран ажиллах юм.



“Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК хөрөнгийн зах зээл, санхүү, бизнесийн мэдээллийг баталгаат эх сурвалжтай, баримтад үндэслэн, шинэлэг санаа, сонирхолтой байдлаар уншигчдадаа хүргэдэг Лимон Пресс Дижитал ХХК-тай хамтран санхүүгийн мэдээ мэдээллийг цаг алдалгүй хүргэж хөрөнгийн зах зээлийн оролцогчдыг ухаалаг шийдвэрт хөтлөхөөр хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.



Хөрөнгийн зах зээлийн мэдээ мэдээллийг тогтмол, цаг алдалгүй хүргэдэг www.marketinfo.mn сайттай хамтран ажиллах ажиллах гэрээ байгуулж, олон нийтэд тогтмол хөрөнгийн зах зээл, үнэт цаасны арилжааны мэдээ мэдээллийг хүргэхээр хамтын ажиллагаагаа эхлүүлсэн.




5.4.3. СУРГАЛТ



Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татаж, IPO хийхээр төлөвлөж буй компаниудын захирлууд, хувьцаа эзэмшигчид, санхүүгийн албаны захирлуудад мэдвэл зохих мэдлэг олгох, зөвлөгөө өгөх, солилцох зорилгоор аудит, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудтай хамтран “IPO-д бэлтгэх нь” сургалт, нетворкинг арга хэмжээ, “Хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах боломж” сургалтыг тус тус зохион байгуулж, 60 гаруй байгууллага хамрагдсан.

5.5. БҮТЭЦ, УДИЛДЛАГА



2023 оны 10 сард Удирдлагын багт өөрчлөлт орж Гүйцэтгэх захирал Б.Гантулга үүрэгт ажлаас чөлөөлөгдөж, Бизнес хөгжил хариуцсан захирлаар ажиллаж байсан М.Даваажаргал Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдсон.

Бирж нь ажилтны ур чадварыг хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, компанийн зөв зохистой соёлыг төлөвшүүлэх бодлого баримтлан ажилладаг бөгөөд баг хамт олноо бүрдүүлэхдээ чадварлаг, авьяаслаг, ажилдаа чин сэтгэлээсээ ханддаг залуусыг сонгон ажиллуулдаг. Эдийн засгийн нөхцөл байдал хүнд байсан ч ажиллагсдаа хувийн тэтгэврийн дансны хуримтлалд хамруулан ажиллаж байна.

06 САНХҮҮГИЙН ТАЙЛАН

УБҮЦБ арилжаа тооцооны шимтгэлд 22 сая төгрөгийн орлого, 19 сая төгрөгийн бүртгэл хураамжийн орлого, бусад үйл ажиллагааны орлогоор 10 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар компанийн балансын нийт хөрөнгийн дүн 2.08 тэрбум төгрөг бөгөөд үүний 19 хувийг эргэлтийн хөрөнгө бүрдүүлж байна.

№	Санхүүгийн тайлангийн хураангуй үзүүлэлтүүд	Дүн (сая төгрөгөөр)	
		2022.12.31-с	2023.12.31-ны үлдэгдэл
1	Орлогын дэлгэрэнгүй тайлангийн үзүүлэлтүүд		
1.1	Борлуулалтын орлого	6.46	41.06
1.2	Борлуулалтын өртөг	0.17	-
1.3	Нийт ашиг	6.29	41.06
1.4	Хүүний орлого	0	0
1.5	Бусад орлого	0.21	10.49
1.6	Ерөнхий ба удирдлагын зардал	1,128.39	1,039.00
1.7	Санхүүгийн зардал	57.16	86.80
1.8	Бусад зардал		0.13
1.9	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.06	0.00
1.10	Хөрөнгө оруулалт / Үндсэн хөрөнгө борлуулснаас үүссэн олз (гарз)	-25	(4.72) (1,079.03)
1.11	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-1,194.19	12.5
1.12	Орлогын татварын зардал	13.00	(1,091.53)
1.13	Татварын дараах ашиг (алдагдал)	-1,207.19	
2	Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүд		
2.1	Нийт хөрөнгийн дүн	2,418.62	2,082.04
2.2	Үүнээс: Эргэлтийн хөрөнгийн дүн	380.57	404.63
2.3	Өр төлбөрийн дүн	753.35	1,508.29